

ИБУИНВУ-ТАЙ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСНЫ 45 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ БОЛЛОО

Энэ жил бид Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улстай дипломат харилцаа тогтоогоод 45 ойг тэмдэглэн өнгөрүүлж байна. XX зууны Монголын гадаад харилцааны түүхэнд тодорхой байр суурь эзэлдгийн хувьд энэ ойг тэмдэглэн өнгөрүүлэх нь зүйн хэрэг билээ. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд манай 2 улсын харилцаа шинэ шатанд гарсан гэдэгтэй судлаачид санал нэгтэй байна.

Ойг тэмдэглэн арга хэмжээний хүрээнд 1 дүгээр сарын 22-ны өдөр Монгол Улсын Гадаад хэргийн яам, Улаанбаатар хот дахь ИБУИНВУ-ын элчин сайдын яам, МУИС-ийн Гадаад хэл, соёлын сургуулиас хамтран ГХЯ-ны “Зөвшилцөл” танхимд “Монгол, Британийн дипломат харилцаа 45 жилд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав.

Эрдэм шинжилгээний бага хурлыг Гадаад хэргийн дэд сайд Б.Энхмандах нээж үг хэлсэн бөгөөд ИБУИНВУ-аас Монгол улсад суугаа Элчин сайд К.Озборн, МУИС-ийн захирал Ц.Ганцог нар товч үг хэлэв.

Манай хүрээлэнгийн захирал доктор, профессор Л.Хайсандай, судлаач Д.Золбоо “Монгол, Британийн харилцааны түүхэн замнал ба Монгол дахь Британи судлалын тойм”, МУИС-ын Монгол хэл судлалын сургуулийн багш доктор, профессор Ж.Бат-Ирээдүй “Их Британи дахь Монгол судлал” болон ГХЯ-ны БТМҮГ-ын дэд захирал, доктор Т.Төмөрчулуун нар илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Монгол-Британийн хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойд зориулан МУИС-ын багш, оюутнуудын дунд зарласан “Британи соёл, судлал” илтгэл уралдааны шагналтнууд өөрсдийн илтгэлээ сонсгож, тоглолтоо үзүүлсэн нь хуралд оролцогчдын сонирхлыг татлаа. Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийг эмхтгэн цувралаар хэвлүүлэх ажээ.

*Мэдээ бэлтгэсэн Д.Золбоо (ОУСХ-ийн эрдэм
шинжилгээний ажилтан, магистр)*